

## 25 АРИУН СҮНС

### 25.1 АРИУН СҮНС: БИ БОЛ

Үнэний сүнс

Эзэний Сүнс, Ариун Сүнс Илгээгдсэн

<sup>26</sup>Би Эцэгээсээ та нар уруу Туслагчийг илгээнэ. Тэр бол Эцэгээс гарах үнэний Сүнс мөн. Тэр ирэхдээ Миний тухай гэрчилнэ. ( Иохан 15:26 АБ 2004)

<sup>4</sup>Миний дотор байгтун. Би ч та нарын дотор байна. Усан үзмийн модонд холбогдохгүй юм бол мөчир өөрөөсөө жимс ургуулж чадахгүйн адил хэрэв та нар Миний дотор байхгүй бол тийм байх болно. ( Иохан 15:4 АБ 2004)

<sup>22</sup>Тиймээс одоо та нар гунигтай байгаа боловч Би та нартай дахин уулзана. Та нарын зүрх баярлана. Та нарын баяр баясгаланг хэн ч та нараас булаахгүй. ( Иохан 16:22 АБ 2004)

[ ] Хэн таныг усан үзмийн модноос таслахыг оролдож байгааг та мэдэх үү? Яагаад?

### 25.2 АРИУН СҮНС: БИ... БОЛНО

Сүнс хэзээ ирсэн мөн Түүний ажил юу вэ?

<sup>27</sup>Би Өөрийн Сүнсийг та нарын дотор оруулж, та нарыг Өөрийн тогтоолуудаар явуулна. Та нар Миний зарлигийг сахихад анхаарах болно.( Езекиел 36:27 АБ 2004 )

<sup>19</sup>Эцэг эхээ хүндэл. Чи хөршөө өөрийн адил хайрла гэжээ. <sup>20</sup>Өнөөх залуу эр Түүнд-Энэ бүхнийг би сахисан. Надад өөр юу дутагдаж байна вэ? гэхэд, ( Матай 19:19-20 АБ 2004

[ ] Сүнсэн дотор алхах нь өөрийн ёс зүйгээр алхахтай адилгүйг та мэдэх үү?

[ ] Түүний шавь байхын тулд таньд юу дутагдаж байна вэ?

### 25.3 Бурханд алагчлах үзэл байхгүй

<sup>23</sup>Петр тэднийг орохыг урьж, зочлов. Маргааш нь тэр босож мөнөөх хүмүүсийн хамт явахад тэдэнтэй Иоппагийн ах дүүсийн зарим нь явжээ. <sup>24</sup>Дараа өдөр нь тэр Кайсарид хүрч ирэв. Тэднийг хүлээж байсан Корнел төрөл садан болон дотны андуудаа дуудаж цуглуулсан байв. <sup>25</sup>Петрийг үүдэн дээр нь ирэхэд Корнел түүнийг угтан, хөлд нь унаж, түүнд мөргөв. <sup>26</sup>Харин Петр түүнийг босгоод -Бос, би ч гэсэн хүн шүү дээ гэв. <sup>27</sup>Ийнхүү ярилцсаар гэрт ороход олон хүн цугласан байлаа.

<sup>28</sup>Тэр тэдэнд -Иудей хүний хувьд харь үндэстэнтэй нөхөрлөх буюу тэдний гэрт зочлох нь ямар ёс бус хэрэг болохыг та нар өөрсдөө мэднэ. Гэвч ямар ч хүнийг бузар, эсвэл цэвэр бус гэж нэрлэх ёсгүйг Бурхан надад харууллаа. <sup>29</sup>Гиймээс дуудахад чинь би түдгэлзэлгүйгээр явж ирэв.

Та нар намайг дуудсан учраа хэлнэ үү? гэв. <sup>30</sup>Корнел -Дөрвөн өдрийн өмнө яг өдийд, есдүгээр цагийн орчимд би гэртээ залбирч байтал гэрэлтсэн хувцастай хүн өмнө минь зогсож, <sup>31</sup>“Корнел ээ, чиний залбирал сонсдож, өглөг чинь Бурханы өмнө дурсагдав. <sup>32</sup>Тэгээд Петр гэгч Симоныг хүрэлцэн ирээч хэмээн урихаар Иоппа уруу хүн илгээ. Тэр тэнгисийн дэргэдэх арьсчин Симоны гэрт байгаа” гэсэн юм. <sup>33</sup>Ийм учраас би тан уруу тэр даруй хүн явуулав. Таны ирсэн тань сайн хэрэг боллоо. Эзэний танд тушаасан бүхнийг сонсохоор эдүгээ бид Бурханы өмнө энд байцгааж байна гэжээ.

<sup>34</sup>Петр ам нээж, -Бурхан бол нүүр тал хардаггүй бөгөөд <sup>35</sup>Түүнээс эмээгч, зөвийг үйлдэгч алив үндэстний хүн Түүнд таалагддаг гэдгийг би үнэхээр сайн ойлгов.

<sup>36</sup>Тэр Израилийн хөвгүүдэд үг илгээн Есүс Христээр дамжуулж энх тайвныг тунхаглажээ. (Тэр бол бүхний Эзэн мөн) <sup>37</sup>Иоханы тунхагласан баптисмын дараагаар Галилаас эхэлж Иудей даяар юу болсныг та нар өөрсдөө мэднэ. <sup>38</sup>Энэ нь Назарын Есүсийн тухай бөгөөд Бурхан хэрхэн Түүнийг

Ариун Сүнс ба хүч чадлаар тосолсон хийгээд Тэрээр диаволд дарлагдсан бүгдийг эдгээн, сайныг үйлдэж явсан тухай юм. Учир нь Бурхан Түүнтэй хамт байсан.<sup>39</sup>Иудейчүүдийн нутаг болон Иерусалимд Түүний хийсэн бүхнийг гэрчлэгчид нь бид билээ. Тэд Түүнийг модонд өлгөж алсан юм.<sup>40</sup>Бурхан Түүнийг гурав дахь өдөр нь амилуулж, ( Үйлс 10:23-40 АБ 2004 )

[ ] Бусдад хэлэх гэрчлэл таньд бий юү?

[ ] Та өөрийгөө бусдаас илүү гэж боддог уу?

#### **25.4 Хүч чадлаар баптисм хүртээх**

<sup>5</sup>Иохан усаар баптисм хүртээдэг байсан бол харин та нар ойрын өдрүүдэд Ариун Сүнсээр баптисм хүртэх болно” гэснийг хүлээхийг тэдэнд тушаасан ажгуу. <sup>6</sup>Тэгээд цуглагсад Түүнээс -Эзэн, энэ цагт Та Израильд хаанчлалыг сэргээх үү? гэж асуусанд <sup>7</sup>Тэр тэдэнд-Эцэг Өөрийн эрх мэдлээрээ тогтоосон тэр цаг, үеийг мэдэх нь та нарын хэрэг биш.

<sup>8</sup>Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд, та нар хүчийг олж, тэгээд Иерусалим, бүх Иудей, Самари тэр байтугай энэ дэлхийн хязгаар хүртэл Намайг гэрчлэх болно гэв.

<sup>9</sup>Тэр ийнхүү айлдсаны дараа тэднийг харж байхад нь дээш өргөгдөж үүлэнд орж тэдэнд харагдахгүй болов. <sup>10</sup>Түүний одохыг харж тэнгэр өөд гөлрөн байсан тэдний хажууд цагаан өмсгөлтэй хоёр хүн зогсоод,

<sup>11</sup>хэлсэн нь -Галилын эрчүүд ээ, юунд та нар тэнгэр ширтэн зогсоно вэ? Та нараас өргөгдөн тэнгэрт аваачигдсан энэ Есүс нь та нарын Түүнийг тэнгэр өөд явсныг нь харсан лугаа адил тийн буцаж ирнэ гэв. ( Үйлс 1:5-11 АБ 2004 )

[ ] Ариун сүнсний баптисмыг та мэдэх үү?

[ ] Баптисмын нотолгоо юу болохыг та мэдэх үү?